



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Амьжиргааг дэмжих орон тооны бус
зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2012 оны А/89 дүгээр тушаалыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус дөрөвдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Төрийн үйлчилгээний тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, иргэдийн санал хүсэлт, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хүрээнд дүүргийн зорилтот бүлгийн иргэнийг нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах эсэх талаар шийдвэр гаргах, халамжийн үйл ажиллагаатай холбогдсон гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үүрэг бүхий Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийг хороо бүрд хавсралт ёсоор байгуулсугай.

2.Холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлд даалгасугай.


3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр сарын
22-ны өдрийн 09 дугаар тогтоолын хавсралт



Амьжиргааг дэмжих орон тооны бус
зөвлөлийн бүрэлдэхүүн

Амьжиргааг дэмжих орон тооны бус
зөвлөлийн дарга:

Хорооны Зохион байгуулагч

Гишүүд:

Хорооны Нийгмийн ажилтан

Төрийн бус байгууллагын төлөөлөл
(Хорооны Засаг даргын санал
болгосноор)

Төрийн бус байгууллагын төлөөлөл
(Хорооны Засаг даргын санал
болгосноор)

Иргэний төлөөлөл
(Хорооны Засаг даргын санал
болгосноор)

Иргэний төлөөлөл
(Хорооны Засаг даргын санал
болгосноор)

Нарийн бичгийн дарга:

Хорооны хөдөлмөр эрхлэлт,
халамжийн асуудал хариуцсан
мэргэжилтэн